



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/00

Бат-Өлзий сум


Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2023 оны төсөв батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 6 дугаар багийн нутаг Цагаан азаргын Хан баян-уулын хормойд 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр гарсан ойн түймэр унтраах шатахууны зардалд 3,637,660 (гурван сая зургаан зуун гучин долоон мянга зургаан зуун жар) төгрөг, хоолны материалын зардалд 1,060,400 (нэг сая жаран мянга дөрвөн зуу) төгрөг, хүнсний зардалд 320,000 (гурван зуун хорин мянга), нийт 5,018,060 (таван сая арван найман мянга жар) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 5,018,060 (таван сая арван найман мянга жар) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН